

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын "МЭДС ТОВ" Өрхийн эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/55НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.Shinjlenmagadlahui ezshaudit.mn Улаанбаатар хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**“МЭДС ТОБ” ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Ч.ЭНХТУНГАЛАГ ТАНАА**

2025.02.25 № 109

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын “МЭДС ТОБ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өрхийн эрүүл мэндийн төв нь нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүждэг. Тайлант онд нэг иргэнээр тооцсон санхүүжилт 997,331.4 мянган төгрөг, дөрвөн тусламж үйлчилгээний 212,643.2 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолыг жишиг болгон өрхийн эрүүл мэндийн төвийн ажилчдын цалингийн хэмжээг нөхөрлөлийн хурлын шийдвэрт үндэслэн 20 хувиар нэмэгдүүлснээр цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 16 хувиар нэмэгдсэн.

4525020165

Дархан сумын МЭДС ТОБ өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 74,7 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 1.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал тус тус эзэлж байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээнэ. Дархан Уул аймгийн Дархан сумын “МЭДС ТОБ” Өрхийн эрүүл мэндийн төв нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР


2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>160,271,977.55</u>	<u>255,147,530.13</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	10,299,648.87
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	10,299,648.87
3121	Төгрөг	-	10,299,648.87
31213	Арилжааны банк дахь харилцах	-	10,299,648.87
33	АВЛАГА	39,766,450.00	93,873,081.65
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	39,766,450.00	93,873,081.65
35	БАРАА МАТЕРИАЛ	120,505,527.55	150,974,799.61
351	Түүхий эд материал	70,089,077.55	96,838,499.61
35110	Тусгай зориулалттай материал	10,137,819.44	15,937,891.50
35130	Эм боох материал	59,951,258.11	80,900,608.11
354	Хангамжийн материал	50,416,450.00	54,136,300.00
35410	Бичиг хэргийн материал	642,500.00	642,500.00
35420	Аж ахуйн материал	49,773,950.00	53,493,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>453,829,058.43</u>	<u>528,699,985.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	453,829,058.43	528,699,985.15
392	Биет хөрөнгө	407,629,446.03	482,640,910.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	268,628,931.00	268,628,931.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(30,963,806.56)	(38,070,373.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,500,000.00	29,798,310.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,444,444.64)	(133,333.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	225,179,262.09	310,318,923.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(85,415,327.51)	(113,117,458.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,003,100.00	36,402,705.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,858,268.35)	(11,186,794.38)
393	Биет бус хөрөнгө	46,199,612.40	46,059,074.88
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(702,687.60)	(843,225.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,778,000.00	45,778,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>614,101,035.98</u>	<u>783,847,515.28</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>614,101,035.98</u>	<u>783,847,515.28</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	614,101,035.98	783,847,515.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	259,148,702.90	259,148,702.90
51101	Өмч: - төрийн	259,148,702.90	259,148,702.90
512	Хуримтлагдсан үр дүн	267,241,203.30	436,987,682.60
51210	Өмнөх үеийн үр дүн	267,241,203.30	267,241,203.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	169,746,479.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	87,711,129.78	87,711,129.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>614,101,035.98</u>	<u>783,847,515.28</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,169,586,474.67	1,396,479,943.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,233,584.35	132,398,604.86
120	Нийтлэг татварын бус орлого	29,233,584.35	132,398,604.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,233,584.35	132,398,604.86
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	23,760,747.20	108,825,765.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	5,472,837.15	23,572,839.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,140,352,890.32	1,264,081,338.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,140,352,890.32	1,264,081,338.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,140,352,890.32	1,264,081,338.80
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,185,166,370.78	1,225,033,464.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,185,166,370.78	1,225,033,464.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,174,210,368.78	1,204,042,021.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	768,254,333.00	799,361,010.00
210101	Үндсэн цалин	458,712,590.00	491,240,023.31
210102	Нэмэгдэл	162,096,693.00	113,466,504.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,426,000.00	73,400,000.00
210104	Урамшуулал	74,019,050.00	120,029,890.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,741,165.83	101,792,699.66
210201	Тэтгэврийн даатгал	66,937,843.18	70,080,434.35
210202	Тэтгэмжийн даатгал	7,875,043.32	8,263,453.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,159,234.66	4,026,126.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,433,549.51	3,882,401.55
210205	Эрүүл мэндийн даатгал	14,335,495.16	15,540,283.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,038,335.00	12,501,464.00
210301	Гэрэл, цахилгаан	2,863,420.00	3,265,666.00
210302	Түлш, халаалт	7,890,239.00	5,982,131.00
210303	Цэвэр, бохир ус	1,700,676.00	1,570,667.00
210304	Байрны түрээс	1,584,000.00	1,683,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,855,492.52	59,615,780.62
210401	Бичиг хэрэг	14,117,925.00	21,252,396.00
210402	Тээвэр, шатахуун	5,458,700.00	5,992,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,132,604.49	2,957,688.62
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,559,300.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,829,377.00	28,693,596.00
210408	Бараа материал акталсны зардал	12,757,586.03	-
2105	Нормативт зардал	93,570,789.76	93,210,985.08
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,570,789.76	93,210,985.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,795,757.68	33,598,816.32
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,075,157.68	15,924,178.32
210604	Урсгал засвар	9,720,600.00	16,369,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,496,650.00	3,186,320.00

210702	Дотоод албан томилолт	1,496,650.00	3,186,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,536,597.00	24,944,192.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,821,497.00	19,838,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,460.00	55,716.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	36,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,004,000.00	3,960,000.00
210807	Газрын төлбөр	146,040.00	98,276.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	457,200.00	2,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,921,247.99	75,830,753.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,698,858.00	3,662,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,727,624.00	14,842,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,494,765.99	57,325,653.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,956,002.00	20,991,443.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,956,002.00	20,991,443.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,956,002.00	17,747,279.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(15,579,896.11)</u>	<u>171,446,479.30</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	:	<u>1,700,000.00</u>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	:	<u>1,700,000.00</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	:	<u>-1,700,000.00</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(15,579,896.11)</u>	<u>169,746,479.30</u>



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,100,586,440.32	1,209,974,707.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,100,586,440.32	1,209,974,707.15
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,100,586,440.32	1,209,974,707.15
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,100,586,440.32	1,209,974,707.15
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,093,410,779.32	1,174,604,243.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,093,410,779.32	1,174,604,243.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,082,454,777.32	1,153,612,800.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	768,254,333.00	799,361,010.00
210101	Үндсэн цалин	458,712,590.00	491,240,023.31
210102	Нэмэгдэл	162,096,693.00	113,466,504.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,426,000.00	73,400,000.00
210104	Урамшуулал	74,019,050.00	120,029,890.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,741,165.83	101,792,699.66
210201	Тэтгэврийн даатгал	66,937,843.18	70,080,434.35
210202	Тэтгэмжийн даатгал	7,875,043.32	8,263,453.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,159,234.66	4,026,126.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,433,549.51	3,882,401.55
210205	Эрүүл мэндийн даатгал	14,335,495.16	15,540,283.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,038,335.00	12,501,464.00
210301	Гэрэл, цахилгаан	2,863,420.00	3,265,666.00
210302	Түлш, халаалт	7,890,239.00	5,982,131.00
210303	Цэвэр, бохир ус	1,700,676.00	1,570,667.00
210304	Байрны түрээс	1,584,000.00	1,683,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,297,906.49	62,348,980.62
210401	Бичиг хэрэг	14,117,925.00	21,252,396.00
210402	Тээвэр, шатахуун	5,458,700.00	5,992,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,132,604.49	2,957,688.62
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,559,300.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,029,377.00	31,426,796.00
2105	Нормативт зардал	59,117,128.00	85,691,094.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,565,128.00	82,697,894.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,552,000.00	2,993,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,746,180.00	45,281,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,812,000.00	4,508,000.00
210602	Тавилга	9,928,600.00	6,660,450.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,284,980.00	17,744,390.00
210604	Урсгал засвар	9,720,600.00	16,369,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,496,650.00	3,186,320.00
210702	Дотоод албан томилолт	1,496,650.00	3,186,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,336,597.00	24,944,192.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,621,497.00	19,838,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,460.00	55,716.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	36,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,004,000.00	3,960,000.00
210807	Газрын төлбөр	146,040.00	98,276.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	457,200.00	2,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,426,482.00	18,505,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,698,858.00	3,662,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,727,624.00	14,842,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,956,002.00	20,991,443.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,956,002.00	20,991,443.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,956,002.00	17,747,279.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,175,661.00</u>	<u>35,370,463.87</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,949,000.00	25,070,815.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,949,000.00	25,070,815.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,949,000.00	25,070,815.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,949,000.00	25,070,815.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(22,949,000.00)</u>	<u>(25,070,815.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>(15,773,339.00)</u>	10,299,648.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		10,299,648.87



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,148,702.90	87,711,129.78	282,821,099.41	629,680,932.09
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,148,702.90	87,711,129.78	282,821,099.41	629,680,932.09
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(15,579,896.11)	(15,579,896.11)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,148,702.90	87,711,129.78	267,241,203.30	614,101,035.98
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	259,148,702.90	87,711,129.78	267,241,203.30	614,101,035.98
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,148,702.90	87,711,129.78	267,241,203.30	614,101,035.98
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	169,746,479.30	169,746,479.30
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,148,702.90	87,711,129.78	436,987,682.60	783,847,515.28



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1209974707	1199675058	10299648.87	99.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1209974707	1199675058	10299648.87	99.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1188983264	1178683615	10299648.87	99.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799361010	799361010	-	100
210101	Үндсэн цалин	491240023.3	491240023.3	-	100
210102	Нэмэгдэл	113466504	113466504	-	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73400000	73400000	-	100
210104	Урамшуулал	120029890	120029890	-	100
210105	Гэрээт ажлын хөлс	1224592.69	1224592.69	-	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101792699.7	101792699.7	-	100
210201	Тэтгэврийн даатгал	70080434.35	70080434.35	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	8263453.33	8263453.33	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	4026126.69	4026126.69	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	3882401.55	3882401.55	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	15540283.74	15540283.74	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12501464	12501464	-	100
210301	Гэрэл, цахилгаан	3265666	3265666	-	100
210302	Түлш, халаалт	5982131	5982131	-	100
210303	Цэвэр, бохир ус	1570667	1570667	-	100
210304	Байрны түрээс	1683000	1683000	-	100
2104	Хангамж, бараа материалын зардал	62348980.62	62348980.62	-	100
210401	Бичиг хэрэг	21252396	21252396	-	100
210402	Тээвэр, шатахуун	5992100	5992100	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2957688.62	2957688.62	-	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720000	720000	-	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31426796	31426796	-	100
2105	Нормативт зардал	85691094	85691094	-	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82697894	82697894	-	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2993200	2993200	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70352755	70352755	-	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	4508000	4508000	-	100
210602	Тавилга	31731265	31731265	-	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17744390	17744390	-	100
210604	Урсгал засвар	16369100	16369100	-	100
2107	Томилолт, зочны зардал	3186320	3186320	-	100
210702	Дотоод албан томилолт	3186320	3186320	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24944192	24944192	-	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19838400	19838400	-	100

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864000	864000	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	89100	89100	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55716	55716	-	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36700	36700	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3960000	3960000	-	100
210807	Газрын төлбөр	98276	98276	-	100
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2000	2000	-	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28804748.87	18505100	(10299648.87)	64.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13962248.87	3662600	(10299648.87)	26.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14842500	14842500	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20991443	20991443	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	20991443	20991443	-	100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3244164	3244164	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17747279	17747279	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1209974707	1209974707	-	100
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1209974707	1209974707	-	100
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1209974707	1209974707	-	100
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10299648.87	10299648.87	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	25	25	-	100
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	29	-	100
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	24	24	-	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	100



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“МЭДС ТОВ” өрхийн эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний багц, жагсаалт болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээ”-ний багцад тус тус заасан тусламж, үйлчилгээг үйлчлэх хүрээний болон түр оршин суугч хүн амд үзүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлж, иргэдийн чирэгдлийг бууруулна.
- Эмнэлгийн мэргэжилтний мэдлэгийг сайжруулах, сургалтад хамруулж чадавхжуулах ажлыг зохион байгуулна.

- Эмч сувилагч, ажилтны сэтгэл зүйг дэмжин, дархлаажуулж дэмжин ажиллах Эмч эмнэлгийн ажилтны ажиллах стандартын дагуу эрүүл таатай, ээлтэй орчныг бүрдүүлэн ажиллах.
- Эмч, сувилагч болон удирдах ажилтан, ажилчдын ёс зүй, хариуцлага хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 5 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 6 дугаар тогтоол,
- Монгол улсын сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01 оны өдрийн А/52 тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймаг Дархан сумын “МЭДС ТОБ” өрхийн эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байдлаар боловсруулан, хууль тогтоомжийн өөрчлөлтийг тухай бүрд шинэчлэн баталж оруулсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл*, мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Дархан Уул аймаг Дархан сумын “МЭДС ТОБ” өрхийн эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,299,6 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	10,299.6	10,299.6
Авлага	39,766.4	93,873.0	54,106.6
Бараа материал	120,505.5	150,974.7	30,469.2
Үндсэн хөрөнгө	453,829.0	528,699.9	74,870.9
Нийт хөрөнгө	614,101.0	783,847.5	169,746.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	614,101.0	783,847.5	169,746.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	614,101.0	783,847.5	169,746.5

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 10,299.6 мянган төгрөг болсон нь 2024 оны эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийн орлого 1,209,974.7 мянган төгрөг бөгөөд 174,604.2 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 54,106.6 мянган төгрөгөөр өссөн нь 11, 12 дугаар сарын гүйцэтгэлийн үр дүн болон 4 тусламж үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар санхүүжүүлэх эх үүсвэргүй болсонтой холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 150,974.7 мянган төгрөг болж 30,469.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр Эрүүл мэндийн яамнаас 2,597.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 20,975.2 мянган төгрөгийн Эм эмнэлгийн хэрэгсэл хандивын материал нийт 23,572.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 103,948.1 мянган төгрөгийн материал зарцуулж, 1,305.5 мянган төгрөгийн эвдэрч хэмхэрсэн ашиглагдахгүй аж ахуйн эд зүйлсийг акталж устгасан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 528,699.9 мянган төгрөг болж 74,870.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 23,260.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,810.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийт өөрийн төсвөөс худалдан авсан 25,070.8 мянган төгрөгийн хөрөнгө. Засаг Даргын захирамжаар машин тоног төхөөрөмж дансанд 75,442.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас 1,040.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 24,998.3 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл нийт хандиваар болон шилжиж ирсэн 101,481.7 мянган төгрөгийн хөрөнгө. Ашиглалтын хугацаа дууссан дахин үнэлсэн хөрөнгө 7,344.0 мянган төгрөгийн хөрөнгө. Нийт үндсэн хөрөнгө 133,896.5 мянган төгрөгөөр өссөн. Дахин үнэлсэн хөрөнгийг данснаас 18,469.8 мянган төгрөгөөр, балансаас баланс хооронд шилжүүлсэн 1,700.0 мянган төгрөгийн хөрөнгө. 12,933.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,956.1 мянган төгрөгийн тавилга эд хогшлын үндсэн хөрөнгө буюу нийт 17,889.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан. Тайлант онд элэгдлийн зардал 57,325.6 мянган төгрөг болсон нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,209,974.7 мянган төгрөг буюу нэг иргэнд ногдох норматив зардлаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2024 онд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80.0 хувийг урьдчилан олгож 20 хувийг гүйцэтгэлийн үр дүнг тооцож олгохоор төлөвлөсөн 4 тусламж үйлчилгээний санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан авахаар төлөвлөсөн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрт зориулан 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,209,974.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,174,604.2 мянган төгрөг 100.0 хувьтай байна. Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,299.6 мянган төгрөг байна. Төсвийн хэтрэлт хэмнэлт гараагүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/							
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71602 эмнэлгийн тусламж үйлчилгээ	1	80508 Төрийн бус байгууллагд төрөөс олгох дэмжлэг	1,209,974.7	1,199,675.0	10,299.7	99.14
Нийт				1,209,974.7	1,199,675.0	10,299.7	99.14

Өрхийн эрүүл мэндийн төв нь нэг иргэд ногдох норматив зардлаас худалдан авах ажиллагаагаар 10 нэр төрлийн бараа үйлчилгээнд 151,300.0 мянган төгрөг төлөвлөснөөс 193,322.0 мянган төгрөг буюу 70,6 хувь гүйцэтгэлтэй байна. 183,894.7 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийж, 9,427.3 мянган төгрөгөөр тендер зохион байгуулж, 21,991.2 мянган төгрөгөөр цахим дэлгүүрээс ерөнхий гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ болон бараа үйлчилгээний бусад зардалд 19,838.4 мянган төгрөг төлөвлөснөөс 100 хувь зарцуулсан.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулаагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлого байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана."

гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн “МЭДС ТОБ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн “МЭДС ТОБ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ” аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 1,185,166.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 23,703.3 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага цалин болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой зардал, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал, тээвэр, шатахууны зардал, багаж, техник хэрэгслийн зардлаас нийт 10,299,6 мянган төгрөг хэмнэсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд улирал тутамд мэдээлэх 4 мэдээллийг 100 хувь байршуулж нийтэд ил болгосон. Мэдээллийн хэрэгжилт 100 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-

ААБ 5.5: АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн МЭДС ТОВ Өрхийн эрүүл мэндийн төв

Тайлант хугацаа: 2024 он

Хүснэгт Б. Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогдолтой биш АГАДҮТ-ыг үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

№	Тодорхойлсон эрсдэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөж тооцох эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
						Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт					
1	Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байх	Тайлант онд батлагдсан төсвөөс ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна.	-	Тийм	Үгүй	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга	Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах". Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 1.1, 1.2, 1.3, 2.1.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна.	Хууль тогтоомжийн заалттай холбоотой асуудал.	Зөвлөмж			
Дүн			-									

Бэлтгэсэн:
Аудитор



Б.Хоролбат
огноо:

Хянасан:

Чанарын хяналтын менежер

Л.Магсаржам
Огноо:

Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК-ийн захирал

С.Оргил
Огноо:

Танилцаж, зөвшөөрсөн



Дархан-Уул аймгийн МЭДС ТОВ Өрхийн эрүүл мэндийн төв

Дарга Ч.Энхтунгалаг

Огноо:

Нягтлан бодогч И.Болормаа

Огноо: